

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/360/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663, Цахим хаяг: naranchimegst@audit.gov.mn Аудитын менежер Б.Долгорсүрэн Утас: 261885, Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn Ахлах аудитор С.Отгонхорлоо Утас: 261740, Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn Аудитор С.Шийлэгмаа Утас: 261740, Цахим хаяг: shiilegmaas@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЭХС	Эрчим хүчний сайд
ЭХЯ	Эрчим хүчний яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/354

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд шинж чанарын хувьд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Яамны урсгал төсвөөс анхан шатны баримтгүйгээр 770,299.1 мянган төгрөгийг харьяа байгууллагад санхүүжилт хэлбэрээр шилжүүлж, тайлант оны зардлыг нэмэгдүүлсэн;
- Анхны өртгөө бүрэн нөхсөн 260,859.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй;
- Бараа материалын тайланг гаргадаггүй, жилийн эцэст 156,885.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тооллого хийж, баталгаажуулаагүй;
- Төрд учирсан хохирлын 48,062.5 мянган төгрөгийн авлагыг буруутай этгээдээр төлүүлээгүй, үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Санхүүгийн тайланд 73,092.5 мянган төгрөгийн газрын бүртгэл давхардсан;

- Албан хаагчдад 35,593.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон;
- Тайлант хугацаанд 11,585.1 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдүүдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-т “элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “оршин байх”, “үнэлгээ ба хуваарилалт”, “толилуулга” батламж м эдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэх, Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээнд Засгийн газрын 2025 оны 115 дугаар тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2025 оны 42 дугаар тогтоолоор 100 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр өөрчлөлт оруулж, тайлант онд 82,411.7 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Эрчим хүчний сайдын 2025 оны А/95, А/261, А/346 дугаар тушаалаар төрийн өмчит үйлдвэрийн газруудад 44,192,817.1 мянган төгрөгийн эрчим хүчний татаас, санхүүжилт олгосон байна.

Бусад асуудал

Эрчим хүчний яамны урсгал төсөв буюу бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас Засгийн газрын “Эгийн голийн усан цахилгаан станц төслийг эрчимжүүлэх тухай” 2025 оны 172 дугаар тогтоолын дагуу байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, судалгааны зардалд 2,552,624.2 мянган төгрөг, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”-ийн хүрээнд 2023 оны 246 тогтоолоор нуур үүсэх талбайн түүх, соёлын өвийн дурсгалт зүйлсийн хяналтын тооллого, судалгааны ажилд 94,949.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
АВЛАГА	48,062,559.00	50,658,154.72
Ажиллагчидтай холбогдсон авлага	48,062,559.00	48,012,559.00
Цалингийн авлага	48,062,559.00	48,012,559.00
Бусад авлага	-	2,645,595.72
Байгууллагаас авах авлага	-	2,645,595.72
УРЬДЧИЛГАА	-	-
БАРАА МАТЕРИАЛ	170,977,063.58	156,885,280.58
Хангамжийн материал	170,977,063.58	156,885,280.58
Бичиг хэргийн материал	13,689,370.00	7,958,330.00
Сэлбэг хэрэгсэл	6,177,500.00	696,000.00
Түлш, шатах тослох материал	5,332,332.00	182,332.00
Бусад хангамжийн материал	145,777,861.58	148,048,618.58
НӨӨЦИЙН БАРАА	-	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	219,039,622.58	207,543,435.30
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,464,042,691.56	4,159,824,367.33
Биет хөрөнгө	4,174,886,488.83	3,871,668,164.56
Барилга, байгууламж, орон сууц	3,562,406,169.62	3,562,406,169.62
Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(711,106,977.85)	(809,515,018.57)
Авто-тээврийн хэрэгсэл	172,125,036.00	172,125,036.00
Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(59,218,757.00)	(87,906,263.00)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	755,265,621.43	730,825,137.99
Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(370,802,174.06)	(460,400,440.76)
Тавилга, аж ахуйн эд хогшил	187,099,959.45	178,901,113.61
Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(134,755,982.77)	(143,559,554.50)
Бусад үндсэн хөрөнгө	1,040,960,839.57	1,040,960,839.57
Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(267,087,245.56)	(312,168,855.40)
Биет бус хөрөнгө	289,156,202.73	288,156,202.77
Программ хангамж	50,842,080.00	50,842,080.00
Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж	(49,425,413.27)	(50,425,413.23)
Бусад биет бус хөрөнгө	287,739,536.00	287,739,536.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	4,464,042,691.56	4,159,824,367.33
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	4,683,082,314.14	4,367,367,802.63
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	14,269,871.00
Өглөг	-	14,269,871.00
Бусад өглөг	-	14,269,871.00
Байгууллагад төлөх өглөг	-	14,269,871.00
НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	14,269,871.00
Засгийн газрын хувь оролцоо	4,683,082,314.14	4,353,097,931.63
-Төрийн	3,271,431,489.68	3,271,431,489.68
Хуримтлагдсан үр дүн	139,537,899.37	(190,446,483.14)
Өмнөх үеийн үр дүн	263,741,484.39	127,913,624.09
Тайлант үеийн үр дүн	(124,203,585.02)	(318,360,107.23)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,272,112,925.09	1,272,112,925.09

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	4,683,082,314.14	4,353,097,931.63
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	4,683,082,314.14	4,367,367,802.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	240,993,021,184.00	135,687,654,597.55
Улсын төсвөөс	240,993,021,184.00	135,687,654,597.55
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	240,916,703,054.00	135,685,565,413.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	76,318,130.00	2,089,184.55
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	33,870,647.56	19,808,996.49
Нийтлэг татварын бус орлого	33,870,647.56	19,808,996.49
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,688,544.00	-
Туслах үйл ажиллагааны орлого	1,688,544.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	32,182,103.56	19,808,996.49
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	241,026,891,831.56	135,707,463,594.04
УРСГАЛ ЗАРДАЛ	241,151,095,416.58	135,725,912,798.27
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,933,420,781.72	7,598,310,288.91
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,827,167,790.76	4,068,712,916.82
Үндсэн цалин	2,379,958,063.18	2,505,779,585.88
Нэмэгдэл	747,412,587.37	962,289,062.24
Унаа хоолны Хөнгөлөлт	371,208,000.00	428,381,966.32
Урамшуулал	328,589,140.21	172,262,302.38
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	481,862,060.71	533,853,796.53
Тэтгэврийн даатгал	329,533,550.58	377,705,940.98
Тэтгэмжийн даатгал	38,983,292.15	41,258,029.50
ҮОМШӨ-ний даатгал	19,538,047.20	21,051,679.36
Ажилгүйдлийн даатгал	18,723,664.05	19,954,661.52
Эрүүл мэндийн даатгал	75,083,506.73	73,883,485.17
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,851,618.13	130,431,715.05
Гэрэл, цахилгаан	70,926,437.80	103,017,482.94
Түлш, халаалт	17,220,195.92	19,597,746.98
Цэвэр, бохир ус	5,704,984.41	7,816,485.13
Хангамж, бараа материалын зардал	90,470,097.00	85,654,483.79
Бичиг хэрэг	32,286,473.00	13,750,403.00
Тээвэр, шатахуун	7,909,800.00	5,150,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,501,100.00	43,005,401.79
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	1,260,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,872,724.00	22,488,679.00
Эд хогшил, урсгал засварын зардал	134,608,615.00	2,483,800.00
Урсгал засвар	134,608,615.00	2,483,800.00
Томилолт, зочны зардал	151,079,903.00	80,317,599.00
Дотоод албан томилолт	151,079,903.00	80,317,599.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,665,012,020.00	2,290,195,924.00
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,636,509,065.00	2,127,663,219.00
Даатгалын үйлчилгээ	5,391,970.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	335,703.00	931,167.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,888,000.00	160,142,313.00
Газрын төлбөр	1,884,282.00	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,000.00	1,437,225.00
Бараа үйлчилгээний бусад зардал	489,368,677.12	406,660,053.72
Бараа үйлчилгээний бусад зардал	123,266,456.00	82,632,733.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	366,102,221.12	324,027,320.72
ТАТААС	221,621,474,900.80	44,192,817,100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	221,621,474,900.80	44,192,817,100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	221,621,474,900.80	44,192,817,100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,596,199,734.06	83,934,785,409.36

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,619,696.00	4,837,800.00
Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,619,696.00	4,837,800.00
Бусад урсгал шилжүүлэг	11,978,897,248.00	82,749,715,739.32
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,100,000.00	-
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,901,263,254.00	82,488,472,930.32
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,533,994.00	247,222,809.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	14,020,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	612,682,790.06	1,180,231,870.04
Төвлөрүүлэх шилжүүлэг	612,682,790.06	960,231,870.04
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	220,000,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	241,151,095,416.58	135,725,912,798.27
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(124,203,585.02)	(18,449,204.23)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	220,000,000.00
Төсөвт байгууллагын орлого	-	220,000,000.00
Дансны орлого	-	220,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	220,000,000.00
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-	-
Гадаад зээлийн үндсэн төлбөр	-	-
Гадаад валютын ханшийн зөрүү	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	519,910,903.00
Үнэ төлбөргүй гарсан зардал - үндсэн хөрөнгө	-	519,910,903.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	519,910,903.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(124,203,585.02)	(318,360,107.23)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	240,993,021,184.00	135,687,654,597.55
Улсын төсвөөс	240,993,021,184.00	135,687,654,597.55
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	240,916,703,054.00	135,685,565,413.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	76,318,130.00	2,089,184.55
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	2,208,010.00	50,000.00
Нийтлэг татварын бус орлого	2,208,010.00	50,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	724.00	-
Туслах үйл ажиллагааны орлого	724.00	-
Бусад нийтлэг татварын бус орлого	2,207,286.00	50,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	240,995,229,194.00	135,687,704,597.55
УРСГАЛ ЗАРДАЛ	240,829,621,006.00	135,387,793,694.55
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,611,946,371.14	7,260,191,185.19
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,826,688,467.30	4,068,712,916.82
Үндсэн цалин	2,377,336,499.19	2,503,056,785.88
Нэмэгдэл	749,180,696.96	962,289,062.24
Унаа хоолны Хөнгөлөлт	371,408,363.64	428,381,966.32
Урамшуулал	328,762,907.51	174,985,102.38
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	481,862,060.71	533,853,796.53
Тэтгэврийн даатгал	329,533,550.58	371,770,780.72
Тэтгэмжийн даатгал	38,983,292.15	41,258,029.50
ҮОМШӨ-ний даатгал	19,538,047.20	21,051,679.36
Ажилгүйдлийн даатгал	18,723,664.05	19,954,661.52
Эрүүл мэндийн даатгал	75,083,506.73	79,818,645.43
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,851,618.13	130,431,715.05

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Гэрэл, цахилгаан	70,926,437.80	103,017,482.94
Түлш, халаалт	17,220,195.92	19,597,746.98
Цэвэр, бохир ус	5,704,984.41	7,816,485.13
Хангамж, бараа материалын зардал	90,942,206.00	77,713,377.79
Бичиг хэрэг	25,103,723.00	8,308,290.00
Тээвэр, шатахуун	10,000,000.00	-
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,501,100.00	43,005,401.79
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	1,260,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,437,383.00	25,139,686.00
Нормативт зардал	246,000.00	-
Нормын хувцас, зөөлөн эдлэл	246,000.00	-
Эд хогшил, урсгал засварын зардал	141,423,646.00	2,483,800.00
Багаж, техник, хэрэгсэл	2,908,531.00	-
Урсгал засвар	138,515,115.00	2,483,800.00
Томилолт, зочны зардал	151,079,903.00	80,317,599.00
Дотоод албан томилолт	151,079,903.00	80,317,599.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,671,717,020.00	2,290,553,299.00
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,636,509,065.00	2,127,663,219.00
Даатгалын үйлчилгээ	5,391,970.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	335,703.00	931,167.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,960,000.00	160,048,913.00
Газрын төлбөр	1,884,282.00	-
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	636,000.00	1,888,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	154,135,450.00	76,124,681.00
Бараа үйлчилгээний бусад зардал	154,135,450.00	76,124,681.00
ТАТААС	221,621,474,900.80	44,192,817,100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	221,621,474,900.80	44,192,817,100.00
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	221,621,474,900.80	44,192,817,100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,596,199,734.06	83,934,785,409.36
Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,619,696.00	4,837,800.00
Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,619,696.00	4,837,800.00
Бусад урсгал шилжүүлэг	11,978,897,248.00	82,749,715,739.32
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,100,000.00	-
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,901,263,254.00	82,488,472,930.32
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжл	57,533,994.00	247,222,809.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	14,020,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	612,682,790.06	1,180,231,870.04
Төвлөрүүлэх шилжүүлэг	612,682,790.06	960,231,870.04
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	220,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	240,829,621,006.00	135,387,793,694.55
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	165,608,188.00	299,910,903.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	220,000,000.00
Төсөвт байгууллагын орлого	-	220,000,000.00
Дансны орлого	-	220,000,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	220,000,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	165,608,188.00	519,910,903.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	165,608,188.00	519,910,903.00
Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	165,608,188.00	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	165,608,188.00	519,910,903.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	165,608,188.00	519,910,903.00

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(165,608,188.00)	(299,910,903.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	-	-
Гадаад зээлийн үндсэн төлбөр	-	-
Гадаад валютын ханшийн зөрүү	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,271,431,489.68	1,272,112,925.09	263,741,484.39	4,807,285,899.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,271,431,489.68	1,272,112,925.09	263,741,484.39	4,807,285,899.16
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	--
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	--
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	--
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	--
Зарласан ноогдол ашиг	-	-	-	--
Тайлант үеийн үр дүн	-	-	(124,203,585.02)	(124,203,585.02)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,271,431,489.68	1,272,112,925.09	139,537,899.37	4,683,082,314.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(11,624,275.28)	(11,624,275.28)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,271,431,489.68	1,272,112,925.09	127,913,624.09	4,671,458,038.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	--
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	--
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	--
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	--
Зарласан ноогдол ашиг	-	-	-	--
Тайлант үеийн үр дүн	-	-	(318,360,107.23)	(318,360,107.23)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,271,431,489.68	1,272,112,925.09	(190,446,483.14)	4,353,097,931.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	%
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл				

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

11100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл				
11200	Кассын оны эхний үлдэгдэл				
12	Татварын бус орлого	135,998,847,000.00	135,685,565,413.00	313,281,587.00	99.7
12200	Тусламжийн орлого	135,998,847,000.00	135,685,565,413.00	313,281,587.00	99.7
122005	Төсвөөс санхүүжих	135,998,847,000.00	135,685,565,413.00	313,281,587.00	99.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,998,847,000.00	134,725,383,542.96	1,273,463,457.04	99.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	135,998,847,000.00	134,725,383,542.96	1,273,463,457.04	99.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,968,895,200.00	7,779,012,903.64	1,189,882,296.36	86.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,775,558,400.00	4,067,958,834.27	707,599,565.73	85.1
210101	Үндсэн цалин	2,597,360,700.00	2,502,302,703.33	95,057,996.67	96.3
210102	Нэмэгдэл	1,348,300,000.00	962,289,062.24	386,010,937.76	71.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	411,792,300.00	428,381,966.32	(16,589,666.32)	104.0
210104	Урамшуулал	418,105,400.00	174,985,102.38	243,120,297.62	41.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	623,383,600.00	533,853,796.53	89,529,803.47	85.6
210201	Тэтгэврийн даатгал	431,205,800.00	371,770,780.72	59,435,019.28	86.2
210202	Тэтгэмжийн даатгал	48,044,500.00	41,258,029.50	6,786,470.50	85.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,022,200.00	21,051,679.36	2,970,520.64	87.6
210204	Ажилгүйдлийн даатгал	24,022,200.00	19,954,661.52	4,067,538.48	83.0
210205	Эрүүл мэндийн даатгал	96,088,900.00	79,818,645.43	16,270,254.57	83.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,111,700.00	130,431,715.05	34,679,984.95	79.0
210301	Гэрэл, цахилгаан	129,835,400.00	103,017,482.94	26,817,917.06	79.3
210302	Түлш, халаалт	25,476,800.00	19,597,746.98	5,879,053.02	76.9
210303	Цэвэр, бохир ус	9,799,500.00	7,816,485.13	1,983,014.87	79.7
2104	Хангамж, бараа материалын зардал	106,679,100.00	77,713,377.79	28,965,722.21	72.8
210401	Бичиг хэрэг	13,467,400.00	8,308,290.00	5,159,110.00	61.6
210402	Тээвэр, шатахуун	20,000,000.00		20,000,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,433,200.00	43,005,401.79	1,427,798.21	96.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,897,300.00	1,260,000.00	1,637,300.00	43.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,881,200.00	25,139,686.00	741,514.00	97.1
2105	Нормативт зардал	208,300.00		208,300.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	208,300.00		208,300.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,245,500.00	2,483,800.00	23,761,700.00	9.4
210601	Багаж, техник хэрэгсэл				
210604	Урсгал засвар	26,245,500.00	2,483,800.00	23,761,700.00	9.4
2107	Томилолт, зочны зардал	92,648,200.00	79,982,497.00	12,665,703.00	86.3
210702	Дотоод албан томилолт	92,648,200.00	79,982,497.00	12,665,703.00	86.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	3,092,469,700.00	2,810,464,202.00	282,005,498.00	90.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,877,275,000.00	2,647,574,122.00	229,700,878.00	92.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,400.00		99,400.00	
210803	Даатгалын үйлчилгээ	4,394,300.00		4,394,300.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,801,600.00	931,167.00	870,433.00	51.6

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	513,900.00	22,000.00	491,900.00	4.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	197,763,200.00	160,048,913.00	37,714,287.00	80.9
210807	Газрын төлбөр	4,679,200.00		4,679,200.00	
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,943,100.00	1,888,000.00	4,055,100.00	31.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,590,700.00	76,124,681.00	10,466,019.00	87.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,590,700.00	76,124,681.00	10,466,019.00	87.9
212	ТАТААС	44,192,817,200.00	44,192,817,100.00	100.00	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	44,192,817,200.00	44,192,817,100.00	100.00	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	44,192,817,200.00	44,192,817,100.00	100.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,837,134,600.00	82,753,553,539.32	83,581,060.68	99.9
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,837,800.00	4,837,800.00		100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	4,837,800.00	4,837,800.00		100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал				
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,488,652,200.00	82,488,472,930.32	179,269.68	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	325,624,600.00	247,222,809.00	78,401,791.00	75.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,020,000.00	13,020,000.00	5,000,000.00	72.2
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		960,181,870.04		
12100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл				
12200	Кассын дансны эцсийн үлдэгдэл				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
610001	Төсвийн байгууллага	1	1		100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	100	93	7	93.0
620001	Удирдах ажилтан	4	4		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	90	83	7	92.2
620003	Үйлчлэх ажилтан	6	6		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	220,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	220,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220,000,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	220,000,000.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	220,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	220,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	220,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-
131106	Хаагдсан данс	-
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	-
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Засгийн газрын 2023 оны 197 дугаар тогтоолоор Эрчим хүчний яамны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталж, Эрчим хүчний сайдын “Эрчим хүчний бүтцийн нэгжүүдийн орон тооны хязгаар батлах тухай” 2023 оны А/135 дугаар тушаал, ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын Б/71 дүгээр тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталж, Засгийн газрын “Яамдын орон тооны хязгаарт өөрчлөлт оруулах тухай” 2025 оны 07 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын “Эрчим хүчний яамны бүтцийн нэгжүүдийн орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” 2025 оны А/222 тушаалаар үйл ажиллагааны чиглэл, эрхэм зорилго, зорилтыг тодорхойлжээ.

Эрчим хүчний яамны эрхэм зорилго нь “Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай тогтвортой нөхцөлийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Тайлант онд тавьсан зорилгоо хэрэгжүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Эрчим хүчний салбарын стратеги төлөвлөлтийн бодлогыг боловсруулах, уламжлалт болон сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний түлшний талаарх бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам боловсруулах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай нийцсэн хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Эрчим хүчний үйлдвэрлэл хангамжийн хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэлийн ашиглалт, аюулгүй байдлыг хангах, эрчим хүчний нүүрсний хангамжийн тасралтгүй, найдвартай байдал, нүүрсний чанар, нөөцийн тогтвортой үйл ажиллагааг хангах, зохион байгуулах;
- Яамны үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулах, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тушаалын хэрэгжилтийг хангуулах, төрийн албаны манлайллыг хангах, төрийн захиргааны албыг шуурхай удирдан, яамны дотоод ажлыг оновчтой төлөвлөн зохион байгуулах;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв боловсруулах, зарцуулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах, төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийн хэвийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;
- Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, төлөвлөгөөний биелэлт, яамны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, төсөл арга хэмжээ, тусламжийн хөрөнгийн үр ашигтай байдалд хяналт тавих, төрийн байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг үнэлэх, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, статистик мэдээлэл гаргах, эрчим хүчний үндэсний баланс гаргах ажлыг зохион байгуулах, эрчим хүчний алдагдлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал боловсруулах;
- Салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмж зөвлөгөө өгөх, эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, ашиглалт, техникийн аюулгүй байдалд хяналт шалгалт хийх, эрчим хүчний барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах, хүлээн авах ажлыг зохион байгуулах, зохицуулах, эрчим хүчний барилга байгууламжийн ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих;
- Салбарын бодлого, хууль тогтоомжийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулах, хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг бүртгүүлэх, хянах, гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах, хянах, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах зорилгоор хууль зүйн техник, арга зүйн зөвлөмжөөр хангах.

Эрчим хүчний яам Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх дараах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах;
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;
- Эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай, ажиллагааг хангах;
- Эрчим хүчний эх үүсвэрүүдийн түлшний баланс гаргах замаар нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг өргөжүүлэх;
- Салбарын эдийн засгийн үр ашигтай байх, санхүүгийн чадавхыг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс болон бусад төрөл)-ний салбарт шинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхыг дээшлүүлэх;
- Эрчим хүчний хангамжийн аюулгүй байдалд хяналт тавих;
- Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай нийцсэн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана гэжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант онд яамны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдмэл, стандартчилагдсан хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн;
- Засгийн газрын “Журамд өөрчлөлт оруулах тухай” 2025 оны 115 дугаар тогтоолоор цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэх цагийн хязгаарыг өөрчилсөн;
- Эрчим хүчний зохицуулах хорооны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2025 оны 42 дугаар тогтоолоор 100.0 хувь хөнгөлөлт үзүүлэх хэмжээг өөрчилсөн;
- Засгийн газрын “Яамдын орон тооны хязгаарт өөрчлөлт оруулах тухай” 2025 оны 07 дугаар тогтоол;

Яамны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтын зарцуулалтад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангаж, дүгнэлт зөвлөмж боловсруулах, үр дүнг тайлагнах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний яам 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/26 тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрчим хүчний яамны тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 391,452.6 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	48,062.5	50,658.1	2,595.6
Бараа материал	170,977.0	156,885.3	(14,091.7)
Үндсэн хөрөнгө	4,464,042.7	4,159,824.4	(304,218.3)
Нийт хөрөнгө	4,683,082.3	4,367,367.8	(315,714.5)
Өр төлбөр	-	14,269.8	14,269.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,683,082.3	4,353,097.9	(329,984.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,683,082.3	4,367,367.8	(315,714.5)

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данснүүдэд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл Нийгмийн даатгалын хэлтэст цалингийн шимтгэлийг илүү төлснөөс шалтгаалан 2,595.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл тайлант онд 114,839.0 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, 15,407.6 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 19,814.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 6,231.5 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 5,150.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 112,327.6 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг тус тус зарцуулснаас шалтгаалан 14,091.7 мянган төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр Эгийн голын усан цахилгаан станцад 519,910.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч шилжүүлсэн, 16,346.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын 2025 оны 811 дугаар тогтоолоор дахин ашиглах

боломжтой 19,808.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хасаж, дахин үнэлж бүртгэснээс шалтгаалан 304,218.3 мянган төгрөгөөр буурсан;

- Тайлант онд газрын төлбөрийн 14,269.8 мянган төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,367,367.8 мянган төгрөг болж, тайлант оны үр дүнгээс шалтгаалан 315,714.5 мянган төгрөгөөр буурсан.
- Эрчим хүчний яамны хэмжээнд санхүүгийн тайланд бүртгэлтэй 87,388.3 мянган төгрөгийн үнэлгээтэй 9 төрлийн лиценз болон программ ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус яамны 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 146,957,935.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлээгүйгээс шалтгаалан төсвийн төслийн саналаас 44,740,151.2 мянган төгрөгөөр бууруулж, 102,217,784.7 мянган төгрөгөөр баталсан байна. Тухайлбал: Цалингийн зардлыг 825,512.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 92,991.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 47,836.5 мянган төгрөгөөр, нормативд зардлыг 277.7 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 433,068.3 мянган төгрөгөөр, томилот зочны зардал 166,016.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,602,764.4 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 78,717.7 мянган төгрөгөөр, төрийн өмчит байгууллагад олгох татаасны зардлыг 87,191,700.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, байр ашиглалтын зардлыг 28,081.2 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 45,670,652.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд баталсан төсвийг 33,781,062.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 135,998,847.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 134,725,383.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 134,725,383.5 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
					Зөрүү	хувь
1	70906	Эрчим хүч, уул уурхайн бодлого	135,998,847.0	134,725,383.5	1,273,463.5	99.1
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,091,620.2	5,131,438.8	960,181.4	84.2
1.2	80421	Шөнийн тарифын хөнгөлөлт	82,411,673.0	82,411,672.9	0.1	100.0
1.3	80422	Эрчим хүчний шилжилт	44,192,817.2	44,192,817.1	0.1	100.0
1.4	80509	ОУ-ын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	4,837.8	4,837.8	-	100.0
1.5	80704	Ахмад дайчин, алдар цолтой	76,800.0	76,800.0	-	100.0

1.6	80802	Ажил олгогчоос, олгох тэтгэмж урамшуулал	343,644.6	260,242.8	83,401.8	75.7
1.7	80814	Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж	179.2		179.2	-
1.8	83105	Төсөл, арга хэмжээний бэлтгэл	2,877,275.0	2,647,574.1	229,700.9	92.0

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгааг авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Засгийн газрын 2023 оны 197 дугаар тогтоолоор Эрчим хүчний яамны стратеги, бүтэц зохион байгуулалтыг 110 орон тоотой баталснаас, 2025 оны 07 дугаар тогтоолоор 10 орон тоог бууруулан баталсан байна. Тус яамны орон тоо дутуу ажиллаж байгаа тул орон тооны цомхотгол хийгээгүй байна. Тайлант оны цалингийн зардалд 4,775,558.4 мянган төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 4,068,712.9 мянган төгрөгийг зарцуулсан;
- Хөдөлмөрийн дотоод журамд заасныг үндэслэн хоолны хөнгөлөлтийг 17.0 мянган төгрөгөөр, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр тогтоосон;
- Гадаад томилолтын төсөв батлагдаагүй, дотоод томилолтын зардлаас 7,197.0 мянган төгрөгөөр гадаад томилолтын арга хэмжээний зардалд зарцуулсныг зөрчлөөр тусгасан болно;
- Тайлант хугацаанд сургалт, семинар, хурал, зөвлөгөөн, судалгааны зардал гараагүй;
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулаагүй;
- Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлыг төсвөөс олгож 48,012.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн боловч авлагыг барагдуулаагүй байна.

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх онд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслийн Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд нуур үүсэх талбайд байрлах Казак иргэдийн булш, бунхныг нүүлгэн шилжүүлэх ажлын гүйцэтгэлийн санхүүжилтээс Шүүхийн шийтгэх тогтоолын дагуу 220,000.0 мянган төгрөгийг бүртгэж, улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 409,511,090.0 мянган төгрөгийг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 371,819,910.0 мянган төгрөгийг хяналт тавин зарцуулж ажилласан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Эрчим хүчний сайдын 2024 оны А/314, 2025 оны А/160 дугаар тушаалаар баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд А/275 тушаалаар өөрчлөлт оруулж, 13 ажил, 2 үйлчилгээ, 5 бараа худалдан авахаар баталж 389,956,632.9 мянган төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 305,916,803.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг аудитын түүвэрт хамруулан шалгаж байгаа бөгөөд үр дүнг ЭХС-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланд тусгана.

Тайлант онд цахим систем, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн зардал, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Эгийн голын усан цахилгаан станц төслийн байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэх төсвийг баталсан боловч Эрчим хүчний яамны урсгал төсвөөс 8,661,396.4 мянган төгрөгийн төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 2,232,753.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ЭХС-ын 2025 оны А/275 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан ЭХЯ-ны урсгал төсвөөс цахим хуудас хөгжүүлэх 143,262.4 мянган төгрөгийн төлөвлөж, гүйцэтгэлээр 136,700.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрчим хүчний яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бараа материалын үлдэгдлийн тооллогоор баталгаажуулаагүй, эд хариуцагч бараа материалын тайлан, зардал, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитор С.Шийлэгмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний яам 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн в/285 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Тус яамны тайлант оны гүйцэтгэл нь өмнөх оны гүйцэтгэлээс 105,425,182.6 мянган төгрөгөөр буюу 43.7 хувиар буурсан тул өөрчилж, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 135,725,912.8 мянган төгрөгөөр тогтоосон нийт зардлын 1.0 хувиар буюу 1,357,259,1 мянган төгрөгөөс тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн шууд захирагчийн төсвийн хэмнэлт, зарцуулалтад хяналт тавьж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж, үнэлгээ хийж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 8,570,385.9 мянган төгрөгийн зөрчлөөс 8,570,385.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, санхүүгийн хяналт хэрэгжүүлээгүй, сул зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас зарлагын 8,570,385.9 мянган төгрөгийн 17 гүйлгээг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, залруулах ажлыг зохион байгуулсан байна”, 19.2-т “Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд сахилын шийтгэл ногдуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Санхүүгийн мэргэжилгүй эд хариуцагчийг томилон ажиллуулсан, эд хариуцагч нь бараа материалын тайланг сар бүр гаргаагүй, нягтлан бодогч хянан баталгаажуулаагүй, мэргэжлийн арга зүйгээр хангаагүй ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүү бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэх.

Энэ нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Эрчим хүчний яамны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй, оны өмнө холбогдох мэдээллийг авч, аудитыг төлөвлөлтийн үе шатны ажилбаруудыг хэрэгжүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар 5 албан шаардлага, 5 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн а/1713 дугаар албан бичгээр УАГ-т ирүүлсэн байна.

Биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн а/3040 дугаар албан бичгээр ирүүлснийг хянаж үнэлэхэд 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг дутуу буюу 80.0 хувийн хэрэгжилттэй, 5 албан шаардлага хүргүүлснээс 3 албан шаардлага бүрэн биелж, 2 албан шаардлагын хэрэгжилт дутуу 75.0 хувийн хэрэгжилттэй, нийт 77.5 хувийн биелсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	5	3,993,362.2	3	3,872,207.0	75.00
Зөвлөмж	5	183,510.8	4	183,510.8	80.00
Нийт дүн	10	4,176,873.0	7	4,055,717.8	77.50

Анхны өртгөөрөө элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлээгүй зөрчил давтагдсан албан шаардлага хүргүүлэх, шилэн дансны цалингаас бусад таван сая төгрөгөөс дээших орлого, зарлагын мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаагүй, давтан гаргасан, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх, бүртгэл давхардсан газрын асуудалд дотоод хяналтад албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрчим хүчний сайдын багц "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц" түүх соёлын өвийг хамгаалах, нүүлгэн шилжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил он дамжин хэрэгжих ажлын төсвийг төсөл хөтөлбөрийн нэгжийн ажил эрчимжүүлэх төсвийг батлаагүй, тус яамны урсгал зардлаас гүйлгэн зарцуулсан 3,692,800.0 мянган төгрөгийн асуудлыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,915.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илрүүлж аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй тайлант хугацааны эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт үүссэнийг авлагаар бүртгээгүй;
- Хан-Уул дүүргийн Татварын газарт газрын төлбөрийг төлөөгүй, өр төлбөрийг санхүүгийн тайланд дутуу тусгаж, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй.

Аудитаар нийт 1,440,363.8 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 484,678.2 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 938,769.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн. Үүнээс, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага.

Нийт илэрсэн зөрчлөөс 1,440,363.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,357,259.1 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны захирамжаар олгосон 2019 оноос хойш ажилгүй байсан хугацааны цалинг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх нийт 48,012.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Эрчим хүчний яамны балансад бүртгэлтэй 73,092.5 мянган төгрөгийн газрыг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвөөс Засгийн газрын “Балансаас балансад шилжүүлэх тухай” 2022 оны 318 тогтоолоор шилжүүлэн авсан боловч газар эзэмших гэрчилгээ байхгүй, тус асуудалд өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, тогтоолын хавсралтад дурдсан газрын м2 хэмжээ, бүртгэлийн үнэ зөрүүтэй, тайлант онд давхардуулан бүртгэсэн гэсэн тайлбартайгаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар 26-ны өдрийн 895 дугаар тогтоолоор данснаас хасах шийдвэр гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эрчим хүчний яамны санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн, шүүгчийн захирамжаар олгосон ажилгүй байсан хугацааны цалинг, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг авч, авлагыг барагдуулах, газрын асуудлыг шалгаж, шийдвэр гаргах арга хэмжээг авч, зөрчлийг арилгаж, ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 185 нэр төрлийн 260,859.4 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг дахин үнэлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна”, 6.2.1-д “элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж, бүртгээгүй, холбогдох байгууллагаас тайлант онд багтаан шийдвэрлүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Эрчим хүчний яамны албан хаагчдын албан байрны тодорхойлолт заасан үндсэн чиг үүргийн ажлыг гүйцэтгэсэн нэр бүхий 42 албан хаагчид 35,593.9 мянган төгрөгийг илүү цагийн хөлсийг нотлох баримтгүйгээр хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4-т “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно”, гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эрчим хүчний яамны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт заасан үндсэн чиг үүргийн ажлыг гүйцэтгэсэн албан хаагчдад нотлох баримтгүйгээр илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Тайлант онд анхан шатны баримтгүйгээр 67,119.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.-т “хүчин төгөлдөр бус

анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засгийн газрын “Эгийн голын усан цахилгаан станц төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2025 оны 172 тогтоолоор Сэлэнгэ мөрний сав газрын эко системд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажилд шаардагдах зардлыг яамны урсгал төсвөөс баталж, 770,299.1 мянган төгрөгийг санхүүжилт хэлбэрээр олгож, тайлант оны үр дүнг нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэх.

2. Үр ашиггүй зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрчим хүний яамны урсгал төсөвт гадаад зочин хүлээн авах төсөв батлагдаагүй, Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал уруу хүндэт зочны танхимын үйлчилгээний зардалд 3,100.0 мянган төгрөг, гадаад томилолтын зардал батлагдаагүй байхад ОХУ-ын Москва хотын айлчлалд 964.1 мянган төгрөг, БНХАУ Харбин хотноо хийх айлчлалд 6,232.9 мянган төгрөгийг Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр тус тус зарцуулсан, мөн Жүр Үр ХХК-д 1,288.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж байх.

3. Бараа материалын тайлан гаргахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.12.15-ны А/198 тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комиссыг байгуулж, эд хөрөнгийн тооллогыг хийсэн боловч бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэлд хэлэлцэж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; гэсний тус тус зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын үлдэгдлийн тооллогыг хагас бүтэн жилээр тогтмол хийж хэвших, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр баталгаажуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХУД-ын НДХ-тэй тайлант хугацааны эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт үүссэнийг авлагаар бүртгээгүй.	1	2,645.6	1	2,645.6			1	2,645.6				
ХУД-ын Татварын газарт газрын төлбөрийг төлөөгүй, ер төлбөрийг санхүүгийн тайланд дутуу тусгаж, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй.	1	14,269.9	1	14,269.9			1	14,269.9				
Дүн	2	16,915.5	2	16,915.5			2	16,915.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан 	1	121,105.0			1	121,105.0						

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>шатны шүүхийн шүүгчийн 2022 оны захирамжаар олгосон 2019 оноос хойш ажилгүй байсан хугацааны цалинг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх нийт 48,012.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;</p> <ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний яамны балансад бүртгэлтэй 73,092.5 мянган төгрөгийн газрыг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвөөс Засгийн газрын “Балансаас балансад шилжүүлэх тухай” 2022 оны 318 тогтоолоор шилжүүлэн авсан боловч газар эзэмших гэрчилгээ байхгүй, тус асуудалд өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, тогтоолын хавсралтад дурдсан газрын м2 хэмжээ, бүртгэлийн үнэ зөрүүтэй, тайлант онд давхардуулан бүртгэсэн гэсэн тайлбартайгаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар 26-ны өдрийн 895 дугаар тогтоолоор данснаас хасах шийдвэр гарсан байна. 																			
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Засгийн газрын 2025 оны "Эгийн голын усан цахилгаан станц" төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 172 тогтоолоор Сэлэнгэ мөрний сав газрын эко системд үзүүлэх өөрчлөлтийг тодорхойлох судалгааны ажилд шаардагдах зардлыг тус яамны урсгал төсвийн ангилалд баталж, зарцуулсан. Уг зардлын 770,299.1 мянган төгрөгийг санхүүжилт хэлбэрээр олгож, тайлант оны үр дүнг нэмэгдүүлсэн байна.	1	770,299.2					1	770,299.2				
Эрчим хүний яамны урсгал төсөвт гадаад зочин хүлээн авах төсөв батлагдаагүй, Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал уруу хүндэт зочны танхимын үйлчилгээний зардалд 3,100.0 мянган төгрөг, гадаад томилолтын зардал батлагдаагүй байхад ОХУ-ын Москва хотын айлчлалд 964.1 мянган төгрөг, БНХАУ Харбин хотноо хийх айлчлалд 6,232.9 мянган төгрөгийг ТНБ даргын шийдвэрээр тус тус зарцуулсан, мөн Жүр Үр ХХК-д 1,288.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.	1	11,585.1					1	11,585.1				
Эрчим хүчний яамны албан хаагчдын ажлын байрны тодорхойлоход заасан үндсэн чиг үүргийн ажлыг гүйцэтгэсэн нэр бүхий 42 албан хаагчид илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон байна.	1	35,593.9			1	35,593.9						
Эрчим хүчний яам/аппарат/ нь 2025.12.15-ны А/198 тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комиссыг байгуулж, эд хөрөнгийн тооллогыг хийсэн боловч бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэлд хэлэлцэж баталгаажуулаагүй байна.	1	156,885.3					1	156,885.3				
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 185 нэр төрлийн тавилга, тоног төхөөрөмжийг 260,859.4 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.	1	260,859.4			1	260,859.4						

Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээнүүдийг бүртгэсэн.	1	67,119.8			1	67,119.8						
Дүн	7	1,423,447.7	-	-	4	484,678.1	3	938,769.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Хариуцлага тооцох Албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас зарлагын 8,570,385.9 мянган төгрөгийн 17 гүйлгээ байршуулаагүй байна.	1	8,570,385.9	1	8,570,385.9				
Дүн	1	8,570,385.9	1	8,570,385.9			-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Санхүүгийн мэргэжилгүй эд хариуцагчийг томилон ажиллуулсан, эд хариуцагч нь бараа материалын тайланг сар бүр гаргаагүй, нягтлан бодогч хянан баталгаажуулаагүй, мэргэжлийн арга зүйгээр хангаагүй ажиллаагүй байна.	1	-					1	-
Дүн	1	-	-	-			1	-
Нийт дүн	2	8,570,385.9	1	8,570,385.9			1	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 344/А0170076

Улаанбаатар хот

САГ-2026/360/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны захирамжаар олгосон 2019 оноос хойш ажилгүй байсан хугацааны цалинг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх нийт 48,012.559.00 /Дөчин найман сая арван хоёр мянга таван зуун тавин есөн/ төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
2. Эрчим хүчний яамны балансад бүртгэлтэй 73,092.516.00 /Далан гурван сая ерэн хоёр мянга таван зуун арван зургаан/ төгрөгийн газрыг Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвөөс Засгийн газрын "Балансаас балансад шилжүүлэх тухай" 2022 оны 318 тогтоолоор шилжүүлэн авсан боловч газар эзэмших гэрчилгээ байхгүй, тус асуудалд өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, тогтоолын хавсралтад дурдсан газрын м2 хэмжээ, бүртгэлийн үнэ зөрүүтэй, тайлант онд давхардуулан бүртгэсэн гэсэн тайлбартайгаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар 26-ны өдрийн 895 дугаар тогтоолоор данснаас хасах шийдвэр гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга /Б.Ерэн-Өлзий/, Ерөнхий нягтлан бодогч /Ч.Ариунсанаа/, Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын дарга дарга Х.Бекболат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

С.Майр

Б.Ж

С.ОТГОНХОРЛОО

С.ШИЙЛЭГМАА

9005109
ATA16937
9027931411





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 345/АД170076

Улаанбаатар хот

САГ-2026/360/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 185 нэр төрлийн 260,859,390.56 /Хоёр зуун жаран сая найман зуун тавин есөн мянга гурван зуун ерэн төгрөг тавин зургаан/ мөнгөний тавилга, тоног төхөөрөмжийг дахин үнэлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж, бүртгээгүй, холбогдох байгууллагаас тайлант онд багтаан шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга /Б.Ерэн-Өлзий/, Ерөнхий нягтлан бодогч /Ч.Ариунсанаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

АТА16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-57.Docx

1526180713



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 346/А0170076

Улаанбаатар хот

САГ-2026/360/НА-СГА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Эрчим хүчний яамны албан хаагчдын албан байрны тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргийн ажлыг гүйцэтгэсэн нэр бүхий 42 албан хаагчид 35,593,877.00 /Гучин таван сая таван зуун ерэн гурван мянга найман зуун далан долоон/ төгрөгийг илүү цагийн хөлсийг нотлох баримтгүйгээр хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4-т "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагчаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно", гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1. "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй"; 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрчим хүчний яамны албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргийн ажлыг гүйцэтгэсэн албан хаагчдад нотлох баримтгүйгээр илүү цагийн хөлсийг хавтгайруулан олгосон зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эрчим хүчний яамны санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн, шүүгчийн захирамжаар олгосон ажилгүй байсан хугацааны цалинг, буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг аваагүй, авлагыг барагдуулаагүй, газрын асуудлыг шалгаж, шийдвэр гаргах арга хэмжээг аваагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газрын дарга Х.Бекболат нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 347/А0170076

Улаанбаатар хот

САГ-2026/360/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд анхан шатны баримтгүйгээр 67,119,884.00 /Жаран долоон сая нэг зуун арван ёсөн мянга найман зуун наян дөрвөн/ төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээг бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга /Б.Ерэн-Өлзий/, Ерөнхий нягтлан бодогч /Ч.Ариунсанаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

(Handwritten signatures)

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА

9006109
АГА16037
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 348/АД 170076

Улаанбаатар хот

САГ-2026/360/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрчим хүчний яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас зарлагын 8,570,385,911.60 /Найман тэрбум таван зуун далан сая гурван зуун наян таван мянга есөн зуун арван нэгэн төгрөг жаран мөнгө/-ний 17 гүйлгээг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19.1-д "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, залруулах ажлыг зохион байгуулсан байна", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга /Б.Ерэн-Өлзий/, Ерөнхий нягтлан бодогч /Ч.Ариунсанаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
С.ОТГОНХОРЛОО
С.ШИЙЛЭГМАА

